



ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Төв аймгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70272582, 99014557
И-мейл: jargalsaihan_tuv@yahoo.com

Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273465, 99859811
И-мейл: amaraa_tuv@yahoo.com

Аудитор: О.Сосор
Утас: 70273204, 97020991
И-мейл: Sosor@yahoo.com

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон
Төв аймаг Зуунмод хот
Цахим хуудас: tuv@audit.gov.mn

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус запруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланда хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохиорох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Зуунмод сумын ЗДТГ-ын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨВ-2015/83/СТА-ТТЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Зуунмод сумын ЗДТГ-ын 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, нягтлан бodoх бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Зуунмод сумын ЗДТГ-ын 2014 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 03 дугаар сарын 25-наас 2015 оны 03 дүгээр сарын 28-ныг хүртэл хийхээр төлөвлөн Төв аймгийн Аудитын газрын санхүүгийн аудитын багийн аудитор О.Сосор хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Зуунмод сумын ЗДТГ-ын 2014 оны төсвийн санхүүгийн тайланг 2015 оны 03 дугаар сарын 25-нд Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Төв аймгийн Аудитын газар аудитыг 2015 оны 03 дугаар сарын 28-наас 2015 оны 04 дугаар сарын 02-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 04 дугаар сарын 10 -нд Зуунмод сумын ЗДТГ-ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцох” журмыг 2014 оны 297 дугаар тогтоолоор хүчингүй болгосон.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дүгээр зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:”

гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тус хуулийн 33 дүгээр зүйлд тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 6.2.-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Зуунмод сумын ЗДТГазрын дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг сумын ИТХурлаас баталж Аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой НББ-ийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 16.5. Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар хэрэгжүүлэх бүрэн эрхийн 16.5.6-д дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэсэн заалтын хэрэгжилт хангартгүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дун:

Аудит хийхэд Нягтлан бodoх бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Зуунмод сумын ЗДТГ-ын төсвийн 2014 оны санхүүгийн тайланда дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансадад түүвэрчилсэн байдлаар 8 аудитын хяналтын горим, 6 нарийвчилсан сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТТЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн acolous программ уялдсан байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөттэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Зуунмод сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бodoх бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв аймгийн Зуунмод сумын ЗДТГ-ын төсвийг Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төв аймгийн Зуунмод сумын ЗДТГ нь 2014 онд орон нутгийн төсвөөс урсгал зардалд 476260.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Үүнээс урсгал зардалд 445938.8 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 30321.6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 12 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 8, нарийвчилсан 6, нийт 14 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал Эдгээр эрсдлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг супруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна .

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Төв аймгийн Зуунмод сумын ЗДТГ-ын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 200,0 мянган төгрөгөөс дээш дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлын 91,5 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна.

1. Төсвийн хөрөнгөөр 34007,3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн горимд шилжих тухай Сангийн сайдын 2014 оны 122-р тушаалын хавсралтын 5.5-д “тавилга, эд хогшлын ашиглалтыг сайжруулж, сийрын 2 жилд үндсэн хөрөнгө бэлдэхгүй байх,, гэсэн заалтыг мөрдөн ажиллах зөвлөмж бичигдсэн.

2. Шүүхийн шийдвэртэй 50000,0 мянган төгрөгийн авлагаас барагдаагүй үлдэгдэл 25266,0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр авлагын данснаас хассан зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн: НББ-ийн тухай хуулийн 7.7-д “анхан шатны баримтгүй ажил гүйлгээг дансанд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн тул буцааж дансанд тусгуулахаар албан шаардлага бичсэн.

3. Мөнгөн хөрөнгийг түүвэрлэн шалгахад 3405,5 мянган төгрөгийн гүйлгээг харилцахаас шууд зардлын дансанд журналын бичилт хийсэн зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн: НББ-ийн тухай хуулийн 7.6-д “анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж бичигдсэн.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын

талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдах материаллаг бус алдаа тогтоогдоогүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Зуунмод сумын ЗДТГ-ын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 62678,8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба үүнээс 25266,0 мянган төгрөгөнд албан шаардлага, 37412,8 мянган төгрөгөнд зөвлөмж бичлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Зуунмод сумын ЗДТГ-ын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд Төв аймгийн Аудитын газраас хийсэн аудитаар 6 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 100 хувийг хэрэгжүүлж, биелэлтийг гарган ирүүлсэн байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт: Зөрчилгүй санал дүгнэлт

Дээрхи алдаа зөрчлийг эс тооцвол Төв аймгийн Зуунмод сумын ЗДТГ-ын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудасыг хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР**

**Л.ЖАРГАЛСАЙХАН
О.АМАРЖАРГАЛ**

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

O.COCOP

Огноо:2015.04.08